

# ➤ Ажлаас гарсан иргэдэд ➤

◆ Уг танилцуулга нь ажлаас гарсан та бүгдэд гол хэрэгтэй мэдээллийг агуулсан бөгөөд, дэлгэрэнгүй мэдээллийг ойролцоох Hello work төвөөс (хөдөлмөрийн бирж) лавлана уу. Мөн “Ажлаас гарсан тухай хуудас-2” -н арын нүүрийг уншиж танилцана уу.

※ Тэтгэмж авахаар бүртгүүлэхэд хувийн дугаар шалгах бичиг баримт (My number карт г.м) шаардлагатай болно.

## ① Хөдөлмөрийн даатгалын ажил хайгчийн тэтгэмж гэдэг нь

Хөдөлмөрийн даатгалын ажилгүйдлийн тэтгэмжид, ажилгүй иргэн нь тогтвортой амьдрангаа, аль болох хурдан ажилд орохын тулд ажил хайх оролдлогыг дэмжих зорилготой тэтгэмж буюу “Ажил хайгчийн тэтгэмж” гэдэг тэтгэмж байдаг. “Ажил хайгчийн тэтгэмж”-д, ерөнхий даатгуулагч бол “Үндсэн тэтгэмж”, өндөр настай даатгуулагч (※1) бол “Өндөр настай ажил хайгчийн тэтгэмж”, богино хугацааны хөдөлмөр эрхэлсэн тусгай даатгуулагч (※2) бол “Тусгай мөнгөн тэтгэмж” зэрэг багтана.

Доорх хэсэгт хамгийн түгээмэл “Үндсэн тэтгэмж” (өөрөөр хэлбэл ажилгүйдлийн тэтгэмж) -г голчлон түүний агуулга болон бүртгүүлэх журмын талаар тайлбарлав.

※1 65-с дээш настай байх ба тусгай даатгуулагч болон тогтсон өдрөөр хөдөлмөр эрхэлдэг даатгуулагчаас бусад иргэн

※2 улирлын чанартай ажилд тодорхой хугацаагаар ажиллаж буй иргэн, улирлаас шалтгаалан ажилд орж гардаг иргэн

Шууд ажил хийх боломжтой хүн бол  
Тэтгэмж авах эрх тогтоох бүртгэл хийнэ

Өвчин, төрөлг, хүүхэд харах, үргүйдлийн эмчилгээ зэргээс үүдэн шууд ажиллах боломжгүй хүн бол тэтгэмж авах хугацааг сунгах хүсэлт гаргах



②-с хойших хэсгийг үзнэ үү.



Хуудас 4-н ⑩-г үзнэ үү.

## ② Шууд ажиллах боломжтой хүн гэдэг нь

“Ажил хийх чин хүсэлтэй ба шууд ажиллах боломж чадвартай (эрүүл мэндийн байдал • гэр бүлийн орчин г.м) идэвхтэй ажил хайж байгаа ч, ажил олдохгүй байгаа” хүнийг хэлнэ.

## ③ Доорх хүснэгтэд заасан хүн зарчмын хувьд ажил хайгчийн тэтгэмж авахгүй

Ажил хайгчийн тэтгэмж (үндсэн тэтгэмж ба бусад) нь, дахин ажилд орохыг эрмэлзэж буй хүнийг дэмжих тогтолцоо. Зарчмын хувьд доорх бүлэгт хамаарах хүнд олгогдохгүй боловч, нөхцөл байдлаас хамааран олгож болох тохиолдол байдаг учир Hello work төвөөс лавлана уу.

- |  |  |
|--|--|
| ① Гэртээ байх хүсэлтэй хүн   | ⑦ Өөрийн нэр дээр бизнес эрхэлдэг хүн  |
| ② Өдрийн оюутан эсвэл оюутантай ижил нөхцөлд байгаа нь тогтоогдсон г.м суралцах зорилготой хүн   | ⑧ Компанийн албан тушаалтан болсон хүн (албан тушаалтанд дэвших төлөвлөгөөтэй болон нэр төдий албан тушаалтан)   |
| ③ Гэр бүлийн бизнес эрхэлдэг ажилд орох боломжгүй хүн  | ⑨ Ажилд орсон, ажил хийж байгаа хүн (туршилтын хугацаанд байгаа хүн орно)  |
| ④ Хувийн бизнес эхлүүлсэн эсвэл бизнес эрхлэхээр бэлдэж байгаа хүн<br>(Ажил хайх явцдаа бизнес эхлүүлэхээр бэлтгэх • төлөвлөж байгаа хүн тэтгэмж авах боломж бий.) | ⑩ Цагийн ажил хийж байгаа хүн (※долоо хоногт 20 хүрэхгүй цаг ажилладаг бол, ажил хийсэн өдөр, орлогын мэдүүлгээ өгөх шаардлагатай ба бусад ажилгүй өдрийн тухайд үндсэн тэтгэмж авч болох тохиолдол байдаг.) |
| ⑤ Дараагийн ажил нь олдсон хүн   | ⑪ Нэг байгууллагад хэд хэд орж гарсан, дахин тэр байгууллагадаа ажилд орохоор зэхэж байгаа хүн   |
| ⑥ Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч болохооргүй богино цагаар хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хүн   |  |



#### ④ Ажил хайгчийн тэтгэмж авах бүртгэл

Хөдөлмөрийн даатгалын ажил хайгчийн тэтгэмж авахын тулд, оршин суугаа газрынхаа хариуцдаг Hello Work төвд (8-р хуудсыг харах) хандаж ажил хайгчийн өргөдөл бөглөх г.м (7-р хуудсыг харах) бүртгүүлэх хэрэгтэй.

Хот муж дүүрэгтэй байрлах бусад Hello Work төвөөс ажил хайх бол лавлана уу.

##### Шаардагдах бичиг баримт

- Ажлаас гарсан тухай хуудас -1 Овог нэр дансны дугаар зэргээ бөглөнө. (доорх зааврыг ашиглана уу)  
Хувийн дугаар бөглөх хэсгийг Hello Work төвийн хүлээн авах дээр ирснийхээ дараа өөрөө бөглөнө.
- Ажлаас гарсан тухай хуудас -2
- My number карт  
My number картгүй бол, дараах ① Хувийн дугаар болон ② Биений байцаалтаа (эх хувь) авчрах.
  - Хувийн дугаар шалгах бичиг (доорх бичгийн аль нэг)  
Хувийн дугаар мэдэгдэх хуудас, хувийн дугаар бичигдсэн оршин суугчийн тодорхойлолт
  - Биений байцаалт (эх хувь) ((1) -н аль 1 төрөл.
    - (1)-т заасан бичиг баримтгүй бол (2)-т заасан бичгээс 2 төрлийн бичиг (хуулбар байж болохгүй))
      - Жолооны үнэмлэх, жолооны түүхийн гэрчилгээ, улсаас хэвлэсэн биений байцаалт, мэргэшлийн гэрчилгээ (зурагтай) г.м
      - Эрүүл мэндийн даатгалын карт, хүүхдийн тэтгэмжийн гэрчилгээ г.м
- Өөрийн тамга (бүртгэлгүй тамга болно • Stamp тамгаас бусад)
- Зураг 2 хувь (ойрын хугацаанд авсан цээж зураг босоо 3.0 см×хөндлөн 2.5см. 1 хувийг ажлаас гарсан тухай хуудас-2 т наах.)  
※ уг бүртгэл болон дараа дараагийн бүртгэлүүдэд My number картаа үзүүлбэл цээж зураг хэрэггүй.
- Өөрийн нэрийн хадгаламжийн дэвтэр (зарим санхүүгийн байгууллагаас бусад)  
Санхүүгийн байгууллага тодорхойлох бичигт санхүүгийн байгууллага тамгалсан бол банкны дэвтэр хэрэггүй.
- Далайчин байсан бол далайчны даатгалын ажилгүйдлийн даатгалын карт болон хөлгийн гишүүний дэвтэр

Бөглөх жишээ

求職者給付等払渡希望金融機関指定届			
フリガナ		ロードウ タロウ	
届出者	1 氏名	労働太郎	
	2 住所又は居所	東京都千代田区霞ヶ関1の2の2	
払渡希望 金融機関	フリガナ	〇×ギンコウ △◇シデン	
	3 名称	〇×銀行 △◇支店	
	4 銀行等	口座番号	1234567
	5 ゆうちょ銀行	記号番号	
		金融機関コード	店舗コード
		8   7   6	3   4   5



◆ Далайчин хүн дахин далайчны ажилд орох хүсэлтэй бол орон нутгийн тээврийн товчоонд ажил хайх өргөдлөө өгч бүртгэл хийлгэнэ үү.

#### ⑤ Ажил хайгчийн тэтгэмж авах болзол 【үндсэн тэтгэмж авах болзол】

- Зарчмын хувьд, ажлаас гарсан өдрөөс өмнөх 2 жилд 12 сараас дээш даатгалын хугацаатай байх. (※1)
- Дампуурал • ажлаас халагдах зэргээс үүдэн ажилгүй болсон тохиолдол (тусгай эрхтэй тэтгэмж авагчид хамрагдана), хугацаат ажлын хөдөлмөрийн гэрээ нь сунгагдаагүй зэрэг бусад аргагүй шалтгаанаар ажилгүй болсон тохиолдолд (тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээдэд хамрагдана) (※2), ажлаас гарсан өдрөөс өмнөх 1 жилд 6 сараас дээш даатгалын хугацаатай байх.
  - ※1 Даатгалын хугацаа гэдэг нь, хөдөлмөрийн даатгалын даатгуулагч байсан хугацаанд, ажлаас гарсан өдрөөс 1 сар тутамд цалин төлөгдсөн үндсэн өдрийн тоо 11 өдрөөс дээш байх сарыг 1 сар гэж тооцно. Рэйвагийн 2-р оны 8-р сарын 1-с хойш ажилгүй болсон бол, цалин төлөгдсөн үнсэн өдөр нь 11 өдрөөс дээш сар нь 12 сард хүрэхгүй тохиолдолд, цалин төлөгдсөн үндсэн цагийн хэмжээ 80 цагаас дээш сарыг 1 сар гэж тооцно.
  - ※2 Тусгай эрхтэй тэтгэмж авагч • Тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээдийн талаар 3-р хуудасны ⑨-г үзнэ үү.
- 《 Ажлаас гарсан тухай хуудас олон байгаа бол, хугацаа хамаарахгүй бүх хуудсаа өгнө үү. 》
- ★ Өндөр настай даатгуулагчид олгох өндөр настай ажил хайгчийн тэтгэмж, богино хугацааны хөдөлмөр эрхэлсэн тусгай даатгуулагчид олгох тусгай мөнгөн тэтгэмж нь ажлаас гарсан өдрөөс өмнөх 1 жилийн хугацаанд 6 сараас дээш даатгалын хугацаатай байх нөхцөлд олгогдоно.

#### ⑥ 1 өдөрт ноогдох тэтгэмжийн хэмжээ 【үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ】

Ажилгүй өдөрт олгогдох 1 өдөрт оногдох мөнгөний хэмжээг “Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ” гэнэ. Зарчмын хувьд ажлаас гарсан өдрөөс өмнөх 6 сард сар бүр төлөгдөж байсан цалин хөлсний нийлбэрийг 180-д хувааж гаргасан хэмжээний (“өдөр тутмын хөлс” гэнэ) ойролцоогоор 50 ~ 80 хувь бөгөөд, цалин хөлс бага байх тусам тэтгэмжийн олгогдох хувь өндөр болно. Түүнчлэн үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээнд дээд • доод хязгаар тогтоосон байдаг.

##### ◆ тооцоолох арга

$$\left( \frac{\text{Ажлаас гарахаас өмнөх 6 сарын нийт цалингийн хэмжээ}}{180} \right) \times (50 \sim 80\%) \times \text{Тэтгэмжийн хувь} = \text{【Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ】}$$

※ 60 ~ 64 настай иргэн бол 45 ~ 80%

## ⑦ Үндсэн тэтгэмжийн тэтгэмж олгогдох өдрийн тоо 【тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо】

◆ Тэтгэвэр, гэрээ дуусах, хувийн шалтгаанаар болих

Даатгуулагч байсан хугацаа / Ажлаас гарсан үеийн нас	10 жил хүртэл	10~20 жил хүртэл	20 - с дээш
65 наснаас доош	90 өдөр	120 өдөр	150 өдөр

◆ Хөгжлийн бэрхшээлтэй г.м ажил олоход хүнд

Даатгуулагч байсан хугацаа / Ажлаас гарсан үеийн нас	1 жил хүртэл	1 жилээс дээш
45 наснаас доош	150 өдөр	300 өдөр
45~65 нас хүртэл		360 өдөр

◆ Тусгай эрхтэй тэтгэмж авагч, тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээд

Даатгуулагч байсан хугацаа / Ажлаас гарсан үеийн нас	1 жил хүртэл	1~5 жил хүртэл	5~10 жил хүртэл	10~20 жил хүртэл	20 - с д э э ш
30 наснаас доош	90 өдөр	90 өдөр	120 өдөр	180 өдөр	—
30 ~ 35 нас хүртэл		120 өдөр	180 өдөр	210 өдөр	240 өдөр
35 ~ 45 нас хүртэл		150 өдөр		240 өдөр	270 өдөр
45 ~ 60 нас хүртэл		180 өдөр	240 өдөр	270 өдөр	330 өдөр
60 ~ 65 нас хүртэл		150 өдөр	180 өдөр	210 өдөр	240 өдөр

### Дараах хүнд нэг удаагийн тусламжийн мөнгө бөөнд нь олгоно.

◆ Өндөр настай даатгуулагч (65-аас дээш настай ажлаас гарсан)

Даатгуулагч байсан хугацаа	1 жил хүртэл	1 жилээс дээш
Өндөр настай ажил хайгчид олгох тэтгэмжийн хэмжээ	30 өдрийн	50 өдрийн

◆ Тусгай даатгуулагч (улирлын чанартай ажил эрхэлж байсан)

Нэг удаагийн тусгай мөнгөн тусламжийн хэмжээ	40 өдрийн
(түр зуурын арга хэмжээ)	

※ 「Даатгалын хугацаа」-д сүүлийн ажлаас гарсан байгууллагаас өмнөх байгууллагын хөдөлмөрийн даатгалд хамрагдаж байсан хугацааг нэмж тооцуулж болно. Гэхдээ тодорхой болзолтой учир дэлгэрэнгүйг Hello Work төвөөс лавлана уу.

## ⑧ Олгож эхлэх болон хугацаа 【хүлээлтийн хугацаа】тэтгэмжийн хязгаарлалт【тэтгэмж авах хугацаа】

Ажлаас гарсан шалтгаан	Халагдсан, тэтгэвэрт гарсан, гэрээний хугацаа дуусч ажлаас гарсан	Хувийн шалтгаан, сахилгын шийтгэлээр ажлаас халагдсан
Тэтгэмж олгож эхлэх	Ажлаас гарсан тухай хуудас, ажил хайх өргөдлөө өгснөөс хойш <b>7 хоногийн ажилгүй өдөр (хүлээлтийн хугацаа)</b> өнгөрсний дараа	Ажлаас гарсан тухай хуудас, ажил хайх өргөдлөө өгснөөс хойш <b>7 хоногийн ажилгүй өдөр (хүлээлтийн хугацаа) + 3 сар (тэтгэмжийн хязгаарлалт)</b> өнгөрсний дараа
Тэтгэмж авах хугацаа	<b>Ажилгүй болсон өдрийн маргаашаас 1 жилийн хугацаанд</b> Уг 1 жилийн хугацаанд тэтгэмж тодорхойлсон өдрийн тоогоор тэтгэмж олгоно. Тэтгэмж авах хугацаа өнгөрвөл тэтгэмж олгох өдрийн тоо үлдсэн байсан ч олгогдохгүй. (Аль болохоор түргэн бүртгүүлнэ үү)	

※ Үндсэн тэтгэмж авахад, зарчмын хувьд 4 долоо хоногт 1 удаа магадлан тогтоох өдөр, ажилгүйдлийн магадлагаа гаргуулах шаардлагатай байдаг.

★ Өндөр настай даатгуулагчид олгогдох өндөр настай ажил хайгчийн тэтгэмжийн мөнгө авах эцсийн хугацаа (тэтгэмж авах боломжтой эцсийн хугацаа) нь **ажлаас гарсан өдрийн дараах өдрөөс тооцод 1 жил болох өдөр**, богино хугацааны хөдөлмөр эрхэлсэн тусгай даатгуулагчид олгох тусгай мөнгөн тэтгэмжийг авах эцсийн хугацаа нь **ажлаас гарсан өдрийн дараах өдрөөс тооцод 6 сар болох өдөр** байна.

## ⑨ Тусгай эрхтэй тэтгэмж авагч, Тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээд гэдэг нь

◆ “Тусгай эрхтэй тэтгэмж авагч” “Тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээд” гэдэг нь **Тусгай эрхтэй тэтгэмж авагч** гэдэг нь, байгууллага дампуурсан, ажлаас халагдсан зэрэг шалтгаанаар дахин ажилд орох бэлтгэл хийх хугацаагүй ажлаас гарахаас аргагүй болсон хүнийг хэлэх ба **тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээд** гэдэг нь, тусгай эрхтэй тэтгэмж авагчаас бусад, тогтсон хугацаатай хөдөлмөрийн гэрээ нь сунгагдаагүй, бусад гарцаагүй шалтгааны улмаас ажилгүй болсон хүнийг хэлнэ. Ямар хүн хамрагдах вэ гэдэг нь тус тус тогтсон байдаг.

◆ “Тусгай эрхтэй тэтгэмж авагч” “Тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээд” -д хамрагдах үгүйг тогтоох Тусгай эрхтэй тэтгэмж авагч, тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээдэд хамрагдах үгүйг тогтоохдоо, ажилгүй болсон шалтгаанд үндэслэн Hello Work төв шийднэ. Ажлаас гарсан шалтгааныг тогтоохдоо, ажил олгогчийн зүгээс тодорхойлсон ажлаас гарсан шалтгаан болон ажлаас гарсан этгээдийн зүгээс тодорхойлсон ажлаас гарсан шалтгааныг харгалзан, тус тусын шалтгааныг нотлох баримтыг нягталж баталгаажуулсны үндсэн дээр, Hello Work төвөөс хянамгай шийдвэрлэнэ.

Тусгай эрхтэй тэтгэмж авагч болон тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээдэд хамрагдах нөхцөлийн талаар Hello Work төвөөс лавлана уу. Мөн Эрүүл мэнд, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны цахим хуудас дахь танилцуулгыг үзнэ үү.

<https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000135026.html>

※ Тогтмол хугацаатай гэрээг давтан шинэчилж байгаа (гэрээний хугацаа нийт 3 жилд хүрэхгүй) ба гэрээний хугацаа нь богиносхох зэрэг хөдөлмөрийн нөхцөл буурч, улмаар гэрээгээ шинэчлэх хүсэлтэй байсан ч шинэчлэхгүй гэсэн заалт орсон зэрэг тохиолдолд, тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээдэд хамрагдах тохиолдолд байдаг.

**10 Шууд ажиллах боломжгүй иргэн бол...65 нас хүрэлгүй ажлаас гарсан тохиолдолд [тэтгэмж авах хугацааг сунгах]**


Ажлаас гарснаас хойш 1 жилийн үндсэн тэтгэмж авах хугацаандаа байхдаа, доорх шалтгааны улмаас ажиллах чадамжгүй болж 30-с дээш өдөр үргэлжилсэн бол, тэтгэмж авах хугацааг сунгах боломжтой.

Мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж авах хүсэлтэй хүн, сургалтад хамрагдах хугацаагаа сунгаж болно.

- ① Өвчин, бэртлийн улмаас ажиллах чадамжгүй (эрүүл мэндийн даатгалын осол гэмтлийн тэтгэмж, хөдөлмөрийн ослын даатгалын амралтын нөхөн төлбөр авч байгаа бол хамрагдана)
- ② Жирэмслэлт, Төрөлт, Хүүхэд өсгөх (3 хүртэлх нас) зэргийн улмаас ажиллах чадамжгүй (үргүйдлийн эмчилгээ орно)
- ③ Төрөл садангийн асаргааны улмаас ажиллах чадамжгүй
- ④ 60-с дээш насны тэтгэвэрт гарсан зэргийн улмаас ажилгүй болж, хэсэг хугацаанд амралт эдлэх (далайчин байсан бол насны болзол өөрчлөгдөнө.)

**Тэтгэмжийн хугацааг сунгах журам**

Шалтгаан	Өвчин, бэртэлт, жирэмслэлт, төрөлт, төрөл садангийн асаргаа г.м	60-с дээш насны тэтгэвэрт гарах г.м
Бүртгүүлэх хугацаа	Ажлаас гарсан өдөр (ажиллах чадамжгүй болсон өдөр)-н дараах өдрөөс 30 хоног өнгөрмөгц даруй бүртгүүлэх журамтай боловч, сунгалт хийсний дараа тэтгэмж авах хугацааны сүүлийн өдөр хүртэлх хугацааны дотор байвал болно.	Ажилгүй болсон өдрийн дараах өдрөөс 2 сарын дотор
Сунгах хугацаа	(үндсэн хугацаа) 1 жил + (ажиллах чадамжгүй хугацаа) уртдаа 3 жил	(үндсэн хугацаа) 1 жил + (амрахыг хүсч буй хугацаа) уртдаа 3 жил
Бүрдүүлэх бичиг	Хугацаа сунгах өргөдөл, ажлаас гарсан тухай хуудас - 2, өөрийн тамга (бүртгэлгүй тамга болно • Stamp тамгаас бусад)	
Өргөдөл гаргах арга	Өөрийн биеэр ирэх, шуудангаар явуулах, төлөөний хүн ирэх (итгэмжлэх бичигтэй байх)	Зарчмын хувьд өөрийн биеэр ирэх
Өргөдөл гаргах газар	Оршин суугаа газрыг хариуцдаг Hello Work төв (тэтгэмж авах эрх тогтоолгосны дараа бол эрх тогтоосон Hello Work төв)	



※ Бүртгүүлэх боломжтой хугацаанд дотор байсан ч, өргөдөл оролтсон тохиолдолд, тэтгэмж авах хугацааны сунгалт хийгдлээ гээд үндсэн тэтгэмжийн тэтгэмж тодорхойлсон бүх өдөр тэтгэмж авч чадахгүй байх магадлал байдаг тул анхаарна уу.

★ Өндөр настай даатгуулагчид олгох өндөр настай ажил хайгчийн тэтгэмж, богино хугацааны тусгай даатгуулагчид олгох тусгай мөнгөн тусламжийн хувьд, тэтгэмжийн хугацааны (тэтгэмж авах боломжтой хугацаа) сунгалт хийгдэхгүй.

**11 Тэтгэврийн зохицуулалтын тухай**

65-с доош насны иргэнд тусгайлан олгогддог өндөр настны тэтгэвэр • хамтран туслалцах нийгэмлэгийн тэтгэвэр болон хөдөлмөрийн даатгалын тэтгэмжийг нэгэн зэрэг авах боломжгүй. Үндсэн тэтгэмж авахаар ажил хайх өргөдөл гаргавал, үндсэн тэтгэмж авч дуусах хүртэл хугацаанд өндөр настны тэтгэвэр • хамтран туслалцах нийгэмлэгийн тэтгэврийн олголт бүгд зогсдог.


Дэлгэрэнгүй мэдээллийг Японы тэтгэврийн байгууллагын салбар газруудаас авна уу.

**12 Үндэсний эрүүл мэндийн даатгал (татвар) бууруулах тухай**

Тусгай эрхтэй тэтгэмж авагч, тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээд гэдэг заалтаар үндсэн тэтгэмж авах иргэнд зориулсан үндэсний эрүүл мэндийн даатгал (татвар) бууруулах тогтолцоо байдаг. (Өндөр настны тэтгэмж авагч, тусгай даатгуулагчийн тэтгэмж авагч нь уг тогтолцоонд хамрагдахгүй.)

Тогтолцоог ашиглахын тулд мэдүүлэх шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг оршин суугаа хот дүүргийнхээ үндэсний эрүүл мэндийн даатгалын газраас лавлана уу.

### 13 Тэтгэмж авах бүртгэлийн дараалал



## 14 Түргэн хугацаанд дахин ажилд орсон тохиолдолд олгогдох тэтгэмж

Hello Work төвд ажил хайх өргөдөл (ажлаас гарсан тухай хуудас) өгөөд, хүлээлтийн хугацаа өнгөрсний дараа түргэн хугацаанд тогтвортой ажилд орсон (※) иргэнд, **дахин ажилд орсон тэтгэмж** олгоно. Ажилд орсон өдрийн өмнөх өдөр хүртэл ажилгүйдлийн тодорхойлолттой, тэтгэмж авах хугацаан дотор үлдсэн үндсэн тэтгэмж олгох өдрийн тоо (үлдэгдэл өдрийн тоо) нь тэтгэмж тодорхойлсон өдрийн 3-ний 1-с дээш [3-ний 2-с дээш] байвал үлдэгдэл өдрийн 60 хувьтай [70 хувь] тэнцэх өдрийн тоог үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээнд үржүүлсэн хэмжээний тэтгэмжийг (1 иен хүрэхгүйг хаяна) авах боломжтой. Тодорхой болзол хангах шаардлагатай.

※ Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч байх, хөдөлмөрийн даатгалын даатгуулагчийг ажиллуулдаг ажил олгогч байх зэрэг

Улмаар, дахин ажилд орсон тэтгэмж авсан иргэн нь, ажилд орсон газраа үргэлжлүүлэн 6 сараас дээш ажиллахаас гадна, 6 сарын хугацаанд авсан цалин хөлс нь хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авахаас өмнөх цалинтай харьцуулахад багассан тохиолдолд, **ажил эрхлэлтийг дэмжих тэтгэмж** авах боломжтой.

Тэтгэмж авах хугацаан дотор тэтгэмж тодорхойлсон өдрийн 3-ний 1-с илүү 45-с дээш хоног үлдэж дахин ажилд орсон тэтгэмж олгох бүлэгт хамрагдахгүй байнгын ажилтнаас бусад хэлбэрээр (1-с дээш жил ажиллах боломжгүй ажил) ажилд орсон тохиолдолд, уг ажлын өдөр тутамд үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээний 30 хувиар тооцож (1 иэн хүрэхгүйг хаяна) **ажил эрхлэлтийн тэтгэмж** олгогдоно.

Аль ч тэтгэмж нь наснаас хамаарч үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээнд хязгаар тогтоосон байдаг.

**Ажлаас гарсан шалтгаанаас хамаарч тэтгэмжийн хязгаарлалт тогтоолгосон бол, хүлээлтийн хугацаа дууссаны дараах 1 сарын хугацаанд, Hello Work төв эсвэл ажил танилцуулах газраар дамжуулж ажилтай болсон тохиолдолд дахин ажилд орсон тэтгэмж, ажил эрхлэлтийн тэтгэмж олгогдоно.**

Дээрх тэтгэмжээс гадна “Байнгын ажилд орох бэлтгэлийн тэтгэмж” гэж байдаг ба эдгээр тэтгэмжийг олгох болзол зэргийн талаар Hello Work төвөөс лавлана уу.

### 60-аас дээш насандаа дахин ажилд орсон бол...

Тодорхой болзол хангасан 60~65 хүртэлх насны (※) хөдөлмөрийн даатгалын даатгуулагчид, өндөр настны үргэлжлүүлэн ажил эрхэлсний тэтгэмж олгогдоно. ※далайчны тухайд төрсөн он сар өдрөөс хамаарч 55-с дээш 60 хүртэлх нас гэх тохиолдол бий.

Өндөр настны үргэлжлүүлэн ажил эрхэлсний тэтгэмжид, **өндөр настны үргэлжлүүлэн ажил эрхэлсний үндсэн тэтгэмж** болон **өндөр настны дахин ажилд орсны тэтгэмж** гэсэн 2 төрөл байдаг.

Өндөр настны үргэлжлүүлэн ажил эрхэлсний үндсэн тэтгэмж нь, хөдөлмөрийн даатгалын үндсэн тэтгэмж зэргийн (дахин ажилд орсны тэтгэмж гэх мэтийн үндсэн тэтгэмж олгосон гэж үзэх тэтгэмжүүд орно) тэтгэмж авалгүй дахин ажилд орсон иргэнд олгогдох тэтгэмж юм. 60 хүрснээс хойших сар бүрийн цалин нь 60 хүрсэн үеийн цалинтай харьцуулахад 75%-д хүрэхгүй тохиолдолд олгогдоно (олгогдох хэмжээ нь сар бүр төлөгдсөн цалингийн 15%-р хязгаарлаж цалин хөлсний багассан хувиас хамаарч төлөгдөнө).

Өндөр настны дахин ажилд орсны тэтгэмж нь, ажлаас гарсны дараа үндсэн тэтгэмж авч буй 60-с дээш 65 хүртэлх насны иргэн тэтгэмж олгох өдөр 100-с дээш үлдсэн байхад дахин ажилд орж (1-с дээш жил ажиллах төлөвтэй), дахин ажилд орсны дараах сар бүрийн цалин нь өдөр тутмын хөлсний 30 өдрийн хэмжээтэй харьцуулахад 75%-д хүрэхгүй тохиолдолд олгогдоно (олгох хэмжээ нь сар бүрд төлөгдсөн хөлсний 15%-р хязгаарлаж цалин хөлсний багассан хувиас хамаарч төлөгдөнө). Гэхдээ дахин ажилд орсны тэтгэмжтэй (дээр дурдсан 14) цуг авах боломжгүй.

**Дахин ажилд орох хамгийн эхний алхам нь өөрийгөө сайн мэдэхээс эхэлнэ.**

**Hello Work төв нь таны хүсэлд нийцсэн ажлын зөвлөгөөг өгч, ажлын байрны мэдээлэл, ажилд бүртгүүлэх бичиг баримт хэрхэн үйлдэх талаар зөвлөх, ажил танилцуулах зэрэг үйлчилгээг үзүүлж байна.**

**Та дахин ажилд орохын тулд Hello Work төвд хандаж ажлын зөвлөгөө аваарай!!**

## Ажил хайх өргөдөл бүртгүүлэх заавар

Ажил хайх өргөдлийн бүртгэлийг бүх Hello Work төвд хүлээн авна.

Хөдөлмөрийн даатгал авах бүртгэл хийх зэрэг бол, оршин суугаа газрынхаа хариуцдаг Hello Work төвд хандана уу.

### ~ 2020 оны 1-р сарын 6-с ажил хайх өргөдөл гаргах зарчим өөрчлөгдөнө ~

**Өргөдөл гаргах арга ① : Hello Work төвд байршуулсан компьютер (хайлт, бүртгэл хийх зориулалттай төхөөрөмж)-т ажил хайх өргөдлийн мэдээллээ оруулсны (түр бүртгэл) дараа хүлээн авах цонхонд очиж бүртгэл хийх.**

※ өргөдлийн маягт (бөглөх хэлбэрээр) бэлэн байгаа.

**Өргөдөл гаргах арга ② : Өөрийн компьютер, таблет, ухаалаг гар утаснаас “Hello Work төвийн цахим сүлжээ”-д холбогдож урьдчилан өргөдлийн мэдээллээ оруулсны (түр бүртгэл) дараа Hello Work төв дээр ирж бүртгэл хийх.**

※ Мэдээллээ оруулсны дараа (түр бүртгэл) **14 хоногийн дотор** (хугацаа дуусах өдөр нь төвийн хаалттай өдөр бол өмнөх нээлттэй өдөр хүртэл байна ) Hello Work төвд ирнэ үү.

※ Урьдчилаад түр бүртгэлээ хийчихвэл, Hello Work төвд ирсний дараа бүртгэл шуурхай явагдана.



### Ажил хайгчийн My page хуудас гэдэг нь (2020 оны 1-р сарын 6~)

Hello Work төвийн цахим үйлчилгээнд “**Ажил хайгчийн My page хуудас**” нээвэл, өөрийн компьютер, таблет, ухаалаг гар утаснаас доорх үйлчилгээг ашиглах боломжтой болж, ажил хайх явц илүү хялбар болно. Хуудас нээхийг хүсвэл 2020 оны 1-р сарын 6-с хойш хүлээн авах цонхонд хандана уу.

- **Ажил олгогчийн хайлт хийх нөхцөл болон хайлтын үр дүнгээ хадгалах** боломжтой.
- Hello Work төвөөс танилцуулсан ажил олгогчийн мэдээлэл болон бүртгүүлсэн мэдээллээ харах боломжтой.
- Захидлын функц ашиглан бүртгүүлсэн ажил олгогчтойгоо харилцах боломжтой. Hello Work төвөөс ажил олгогчийн мэдээлэл болон мэдэгдэл илгээх тохиолдол байдаг.

<Анхаарах зүйл>

- Ажил хайгчийн My page хуудас нь, Hello Work төв болон Hello Work төвийн цахим үйлчилгээг ашиглаж ажил хайхыг хүссэн хүнд зориулсан ажил олгогчийн мэдээлэл хайх, харах зэрэг үйлчилгээг үзүүлэх зорилготой юм.
- “Ажил хайгчийн My page хуудас” нээхэд Hello Work төвд бүртгүүлэх хэрэгтэй. Ажил хайх явц дуусгавар болсон бол зарим үйлчилгээг ашиглах боломжгүй болно.
- Ажил хайгчийн My page хуудас нээхэд, нэвтрэх нэр болгож ашиглах и-мэйл хаяг (компьютер, ухаалаг утас зэргийн) хэрэгтэй учир хүлээн авах цонхонд бүртгүүлнэ үү. Улмаар, үйлчилгээний нөхцөл болон нууцлалын бодлогыг зөвшөөрөх нөхцөлтэй.

# Зөвлөгөө өгөх газруудын жагсаалт

Гэрийнхээ ойролцоох Hello work-г эндээс хайх боломжтой.

<https://www.mhlw.go.jp/content/000637894.pdf>



Орчуулагчтай Hello Work бол мэдээллийг эндээс авна уу

<https://www.mhlw.go.jp/content/000592865.pdf>



Хөдөлмөрийн нөхцлийн талаар зөвлөгөө авахыг хүсвэл мэдээллийг эндээс авна уу

[https://www.check-roudou.mhlw.go.jp/soudan/foreigner\\_eng.html](https://www.check-roudou.mhlw.go.jp/soudan/foreigner_eng.html)

